



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/87

Алтай хот

Дотоод аудитын хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: -Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч
(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: -Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга

Гишүүд:

- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
- С.Галсанчоймбол (ТББ-ын төлөөлөл)
- М.Мөнхбаатар (Иргэн)

2. "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Сангийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 29 дүгээр тушаалыг мөрдөж ажиллахыг Дотоод аудитын хороонд даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Дотоод аудитын хороо байгуулах тухай" аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/419 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

